

“Бодь мөрийн зэрэг” зохиол дахь багшийн ёс зүйн тухай

Дашдоржийн ОЮУНГЭРЭЛ*

Монгол Улс, Улаанбаатар,
Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх Ухааны Сургууль,
Философи, шашин судлалын тэнхим

Гомбосүрэнгийн ЭРДЭНЭБАЯР*

Монгол Улс, Улаанбаатар,
Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх Ухааны Сургууль,
Философи, шашин судлалын тэнхим

Received: Aug 21, 2024

Revised: Oct 7, 2024

Accepted: Nov 6, 2024

Хураангуй: Энэхүү өгүүлэлд багш мэргэжлийн ёс зүйн асуудлыг “Бодь мөрийн зэрэг” зохиолд хэрхэн өгүүлснийг товч авч үзэх юм. Мэргэжлийн ёс зүй гэдэг нь тухайн салбарын мэргэжилтнүүдийг чиглүүлдэг ёс суртахууны зарчим, ёс суртахууны хэм хэмжээ, үнэт зүйлийг хэлнэ. Тэнд тухайлбал, шударга байдал, чадвар, хариуцлага, хүндэтгэл, мэргэжлийн хил хязгаар, тасралтгүй суралцах, сайжруулах зэрэг үнэт зүйлс чухал байдаг. Хүн төрөлхтний соёл, шашин, сэтгэлгээний салиггүй нэгэн хэсэг болсон буддизм нь үзэл баримтлалаараа дамжуулан хүн хоорондын харилцааг зохицуулах үйлийг зөв чиглүүлж иржээ. Энэхүү өгүүлийг бичихдээ хоёр асуултыг тодруулахыг зорьсон юм. Нэгдүгээрт, шинжлэх ухаан, техник технологи өндөр хөгжсөн орчин үед хуучны судар бичиг рүү эргэж хандах шаардлага байна уу? Хоёрдугаарт, зөвхөн буддизмын хүрээнд дагаж мөрдөж байсан ёс суртахууны уламжлалыг нийт иргэний боловсролд холбогдуулан тайлбарлаж болох уу? зэрэг болно. Товчхондоо багш шавийн харилцаа, багшийн ёс зүйн талаар судар бичгүүдэд хэрхэн тусгаж, тайлбарласныг эргэн санах хэрэгцээ шаардлагын улмаас энэхүү өгүүлийг бичив.

* © Д.Оюунгэрэл 2024

Email: oyungerelnum@gmail.com

* © Г.Эрдэнэбаяр 2024

Email: erdenebayar.g@num.edu.mn

Түлхүүр үг: ёс суртахуун, нэр хүнд, сургах ёс, сонсох ёс, хүндлэл, харилцаа, зэрлэг зусар сэтгэл

On the Ethics of the Teacher in the Novel “The Path of Bodhi”

OYUNGEREL Dashdorj

*Department of Philosophy and Religious Studies
School of Arts and Science
NUM, Ulaanbaatar, Mongolia*

ERDENEБAYAR Gombosuren

*Department of Philosophy and Religious Studies
School of Arts and Science
NUM, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: *In this article, briefly considers how the teacher's ethics are described in the book The Great Treatise on the Stages of the Path to Enlightenment by Je Tsongkhapa. Professional ethics refers to the ethical principles, moral norms, and values that guide professionals in a particular field. For example, the values include integrity, competence, responsibility, respect, maintaining professional boundaries, and committing to continuous learning and improvement are important. Buddhism, an integral part of human culture, religion, and thought, has historically guided human relationships through its concepts. In writing this article, I aimed to highlight two questions: First, is there any need to return to consider the moral idea of ancient scriptures in today's era of advanced science and technology? Second, can specific Buddhist moral traditions be interpreted and applied to general education? In summary, this article was written to specify the requirement of recollection of how the scriptures reflect and elucidate the teacher-student relationship and teacher ethics.*

Key words: *morality, reputation, teaching ethics, listening ethics, respect, relationships, wild flattery*

1. Удиртгал

Монголчуудын эртнээс нааш эрхэмлэн дээдэлж ирсэн хүний нэг бол багш юм. Багшийн дүр төрхийг үлгэр домог, ардын аман зохиол зэргээс харж болохоос гадна Монголд буддизм түгэн дэлгэрсэн цагаас түүний номлол сургаал дахь ёс зүйн агуулга багшийг тодорхойлоход чухал нөлөөтэй болсон гэж хэлж болно. Техник технологийн хувьд бид өмнөх зуунуудаас харьцангуй хол түрүүлсэн боловч хүмүүний сэтгэлгээ, хандлага тэрхүү үсрэнгүй хөгжлийг гүйцэхүйц гэхэд хэцүү. Энэ тухай “Өнөө цагийн хөгжил дэвшлийн агуулга шинжлэх ухаан, технологийн өсөлтийн эрэмбэ, зам ёсны хөгжлийн үйл явцуудтай харилахгүйгээр хүний сэтгэл зүрхийг эзэмдэн гэгээрүүлэх чадал,

боломж зөвхөн буддын шашинд байдаг” (Зонхав, 2006) хэмээн тун оновчтой өгүүлсэн байдаг.

“Бодь мөрийн зэрэг” зохиолын нэгэн чухал хэсэг нь багш шавийн харилцааны ёс зүйн тухай асуудлыг нарийн тусгасан болохыг харж болно. Багш гэж хэнийг хэлэх, ямар эрдэм мэдлэгтэй байх, хэрхэн үлгэр дуурайл үзүүлж явахыг тодорхой заасан нь зөвхөн тэр хүрээндээ хязгаарлах боломжгүй өргөн агуулгатай нарийн тодорхойлжээ. Богд Зонхавын “Бодь мөрийн зэрэг” зохиол багш, шавийн харилцааны ёс зүйгээр эхлэх бөгөөд тэнд “гэгээрлийн замыг гэрэлтүүлэгч” хэмээх ойлголт тус бүтээлийг бүхэлд нь тийн нэрлээд буй боловч цаанаа багшийг хэлсэн агуулга шууд харагддаг.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Эх зохиолын агуулгыг шинжлэх аргыг голчлон хэрэглэв. Тус өгүүллийг бичихэд доктор, профессор Т.Булганы орчуулга Богд Зонхава “Бодь мөрийн зэрэг” зохиол, доктор Г.Мягмарсүрэнгийн “Бодь мөрийн зэргийн дээж бичиг”, доктор Д.Наранцэцэгийн “Богд Зонхавын намтар” зэрэг бүтээлийг гол хэрэглэгдэхүүн болов.

3. Судалгааны хэсэг

Багш бол төгс гэгээрсэн нэгэн байх бөгөөд *“ганц нэг гэм нүглээс салж, зарим нэг эрхэм чанар эзэмших төдийхөн биш, бүх эрхэм чанарыг төгс цогцлуулна гэсэн үг”* (Зонхав, 2006) хэмээсэн нь нүглээс ангижирсан, эрхэм чанарыг цогцлуулсан нэгэн байх ажээ. Өөрөөр хэлбэл бие, сэтгэл, оюуны хувьд өв тэгш нэгэн байхыг илтгэсэн хэрэг болно. Онолын сургаал номлолыг сайтар эзэмшин, улмаар түүнийг хэрэгжүүлэх зарчмыг хэлбэрэлтгүй дагах ёстой. Үүнийг “Бодь мөрийн зэрэг” зохиолд “уралдааны морь уралдах газрыг тогтсоны хойно гэнэт газраа өөрчлөх нь зохимжгүй” хэмээжээ. Мэдлэгээ буруу зүйлд ашиглаж, зарчмаас хазайж буруу замаар явж болохгүй гэсэн санаа хэмээн ойлгож болно.

Багшийн эцсийн зорилго бол бусдад туслах явдал юм. Түүний тулд,

Өөрөө гарцаагүй ухаарсан зүйлээ

Өрөөл бусдад ойлгуулах хүслээр

Огт алдаа эндэгдэл гаргахгүйгээр

Ухаантнууд шавь нартаа сургадаг ажээ.

Багш бол ашиг хонжоо, алдар нэр, эд хөрөнгө харалгүй шавийг төлөвшүүлэх ёстой. Энэ бол багшийн баримтлах зарчим бөгөөд өдөр тутамдаа биелүүлэх болно.

Номын өглөгийн эзэн бол багш юм. “Бодь мөрийн зэрэг” зохиолд номын өглөгийн үр дүнг тодорхой нэрлэсэн байх бөгөөд түүнийг оюуны, ёс

суртахууны, сэтгэлийн, итгэлийн зэрэг сайн үйлээр нарийвчлан дараах байдлаар ангилан харуулж болохоор байна. Үүнд,

Хүснэгт 1. Номын өглөгийн үр дүн

Оюуны сайн үйл	Ёс суртахууны сайн үйл	Сэтгэлийн сайн үйл	Итгэлийн сайн үйл
Ой санамж сайжрах	Шунал хүсэл багасах	Уур уцаар багасах	Гэгээрэгсдийн таалалд нийцэх
Ухаан саруулсах	Тууштай болох	Муу сэтгэлд автагдахгүй болох	Хүнээс бусад нь хамгаалах
Ухаарч ойлгох	Бусдын итгэлийг олох	Муугийн хорлолд өртөхгүй	Элгэн садангууд орхихгүй
Билиг оюунтай болох	Хүлээцтэй болох	Айх аюулгүй болох	Мэргэд сайшаан магтах
Билиг билгүүнтэй болох	Атаархал үгүй болох		
Төөрөгдөлгүй болох	Нигүүлсэх, асрах сэтгэлээр бусдад хандах		
Номын өглөг нь хожим дурсагдах			

Энэхүү хүснэгтээс харахад номын өглөгийн ач тус хязгааргүй, үүнийг эзэмшсэн багшийн үлгэр дуурайл гайхамшигтай болохыг харуулсан байна. Жишээлбэл, омгоос хагацах, үл хилэгнэх, эсэргүүцлийг үл эрэх зэрэг сайн үйлийн олон чанарыг эзэмшин хүндлэлийг хүлээнэ.

“Бодь мөрийн зэрэг” зохиолд багшийн хамт олны дунд хэрхэн биеэ авч явбал зохилтойг “Номын нөхдөө хайрлах нь зүйтэй” хэмээн бичжээ. Энэхүү санааг дэлгэрүүлэхийн өмнө 2022 онд хийсэн “Багшийн ёс зүйн өнөөгийн байдал” (Баярчимэг, 2023) судалгааны тайланд хамт олны дунд харилцааны ёс зүйн ямар зөрчил дутагдал гардгийг харуулсныг авч үзье. Тухайлбал, *Таныхаар багшийн харилцааны ёс зүйн хамгийн тулгамдсан асуудал юу вэ?*



Зураг 1. Багшийн харилцааны ёс зүйн тулгамдсан асуудал

Багшийн харилцааны ёс зүйн хамгийн тулгамдаж буй асуудлыг тодруулахад 19.3% нь бухимдал, стрессээ зөв тайлах аргыг заах; 18.9% нь мэргэжлийн ёс зүйн мэдлэг дутмаг; 14.3% нь хамтач, багаар ажиллах чадвар сул; 13.4% нь хүний эрхийн талаарх мэдлэг, мэдрэмж сул; 8.9% нь ахмад багш нарын үлгэр дуурайл бага; 6.8% нь хамт олны дунд ялгаварлан гадуурхалт их; 5.6% нь байгууллагын соёлын төлөвшил тааруу гэж хариулсан байна. Судалгаанаас өөр нэг асуудлыг мөн харуулъя.

Судалгаанд оролцогчдын насны ангиллаар нь хамт олны дунд харилцааны ёс зүйн ямар доголдол илүү гардгийг харьцуулбал:

Хүснэгт 2. Хамт олны дунд гардаг харилцааны ёс зүйн доголдол

Нас	Өөрийгөө магтах, хэт үнэлэх	Биеэ тоох, бардам зан	Суралцагчийг ялгаж харилцах	Хамт олны эв нэгдлийг эрхэмлэдэггүй	Зохисгүй үг хэрэглэдэг	Цахим орчинд зохисгүй	Нийт хувь
20-29	24.5	27.4	9.8	24.1	11.8	2.5	100%
30-39	25.6	24.4	9.9	28.3	8.4	3.3	100%
40-49	23.6	20.3	13.5	32.2	8.0	2.5	100%
50-с дээш	24.5	21.2	13.6	26.3	8.6	5.9	100%

Эндээс харахад хамт олны харилцаанд эв нэгдлийг үл эрхэмлэх, өөрийгөө магтах, биеэ тоох гэх мэт ёс суртахууны зохисгүй үйлдлүүд түгээмэл байгаа нь харагдана. Энэхүү асуудлыг хэрхэн шийдвэл зохилтойг бидний авч үзэж буй эх

зохиолд дараах байдлаар авч үзсэн байна. Номлолыг янз бүрээр зөрчдөг хэмээн тус зохиолд бичжээ. Тиймээс тэр бүхнээс ямагт сэргийлж явах ёстой. Тухайлбал, тус бүтээлд нэрлэснээр номын нөхдөө хайрлах нь зүйтэй гээд багш хүн дараах зүйлсээс юуны түрүүнд татгалзахыг заажээ. Үүнд:

- 1) Бусад надаас илүү гарчих вий хэмээх атаархал
- 2) Хойш тавин залхуурах
- 3) Ахин дахин номлохоос зүрхшээх
- 4) Өөрийгөө магтан өрөөлийг муулах
- 5) Номоо харамлах
- 6) Эд таваар горьдох зэрэг болно.

Тухайлбал, эд таваар горьдохыг цээрлэ хэмээхийг дэлгэрүүлбэл:

Ужиг өвчтэй ч эм гуйхгүй

Унтмаар байсан ч хэвтэр гуйхгүй

Умдаасаж өлслөө ч идэш гуйхгүй

Улаан нүцгэрсэн ч хувцас гуйхгүй

Улдаж тамирдсан ч унаа гуйхгүй

Учир нь багш шунах ёсгүй хэмээн бичжээ.

“Өөрийн сэтгэлийг номхруулж чадаагүй хүн бусдын сэтгэлийг номхруулж чадахгүй” хэмээн үздэг байна. Шунал хүсэл, омгорхол зэрэгт хүлэгдэн шавиас мөнгө, эд таваар хүсэх нь товчхондоо сэтгэлээ номхруулж чадаагүйн илрэл мөн. Үлгэрлэж чадахгүй хүн өндөр шаардлага тавих боломжгүй гэсэн санаа энд тодорхой байна. “Ёс суртахуун бол номхроогүй хүний хазаар” (Зонхава, 2006) юм. Сэтгэлээ номхотгоно гэдэг нь ёс суртахууны хэм хэмжээ, зарчмыг дагаж мөрдөнө гэсэн үг ажээ.

Хүндлэхийн дээдээр хүндлүүштэй нь багш гэдгийг “Бодь мөрийн зэрэг” зохиолд тодорхой гаргаж тавьжээ. Тухайлбал, “Багшийн хуран мэдэхийг эс төрүүлбээс олох эрдмийг эс олоод, нэгэнт олсноо алдаж, зөв газар байдаггүй, эс хүндэлснээс ном увдис байдаггүй” (Мягмарсүрэн, 2021) хэмээн бичжээ. Багш хүн яагаад хүндлэгддэг вэ? гэдгийг мөн нарийн гаргаж тавьжээ. Шавьдаа хүндлэгдэхийн учир бол багш шавийг сургахдаа сайнаар сэтгэ, буяныг үйлдэх шалтгааныг заадагт учир орших ажээ.

Зэрлэг зусар сэтгэлийн тухайд: Ном сонсох шавьд өндөр шалгуур тавьсан болохыг тус зохиолоос харж болно. Юуны өмнө шавь болж хүн шавийн эрхэм чанарыг хүлээн зөвшөөрнө. Шавийн шинж бүрдээгүй хүнд ном заахад хэдий багшийн буруу байгаагүй ч өөрийн алдаа дутагдлыг түүний буруу мэтээр хүлээн авдаг байна.

Хүссэн хүнд ном заа, гэхдээ хүссэн байлаа ч хэрэгжүүлж чадах эсэхийг шинж. Хэрвээ хэрэгжүүлж чадах аваас өөрөө хүсээгүй байсан ч заах хэрэгтэй гээд ном сонсохоор ирсэн шавьд багш нь өөрийгөө магтан, номчирхохгүй даруухан байхыг сануулжээ. Шавь хүн багшаас суралцахдаа багшийг шүтнэ.

Харин шүтэх багшийн шинжийг тус зохиолд “номхорсон, амгалан, амарлингуй, хичээнгүй, арвин мэдлэгтэй, энэрэнгүй, ажилдаа дур сонирхолтой, уран илтгэдэг” байх гэжээ. Гэхдээ багшийг шүтэх нь хэтийдэж **“зэрлэг зусар сэтгэл”** болон хувирч болохгүй хэмээсэн нь оновчтой юм. Багшийг хүндлэх нь сурах мэдэхийн үндэс боловч шүтэх ёсыг ойлголгүй шүтэх нь “осолдох хэрэг ирэх” (Мягмарсүрэн, 2021) хэмээн анхааруулжээ. Тиймээс шавь хүн шударга, ухаалаг, номд дур сонирхолтой нэгэн байх ёстой. Аливааг сохроор даган дуурайж, шүтэх ёсыг гажуудуулж болохгүйг ийн зэрлэг зусар сэтгэл хэмээх ойлголтоор илэрхийлжээ. Шүтэх ёсыг мэдэхгүйгээр шүтэх нь ач тус гарах нь байтугай хохирол болдог байна.

Зэрлэг зусар сэтгэл туйлшралыг үүсгэнэ. “Нэг талыг барьж туйлшрахгүй байхыг шударга ёс хэмээнэ” гэжээ. Өөрийн бодолдоо хэт баригдан бусдын үзэл бодол, өөр бусад номлол сургаалыг үгүйсгэн тэмцэх нь туйлшрал болно. Багш нь шавьдаа анхааруулан ийм хандлага байгаа эсэхийг шалган, хэрвээ байгаа бол тэр даруйд засахыг зөвлөнө. Энэ нь зэрлэг зусар сэтгэлийг үүсгэхгүй байх нөхцөл болохыг “Бодь мөрийн зэрэг” зохиолд өгүүлдэг. Харин ухаалаг гэдэг нь зөв, бурууг ялгах оюуны чадварыг хэлдэг байна. Ухаалаг шавь өөрийн буруу дадлыг орхиж, сайныг дагаж үргэлжлүүлэн залгамжилдаг. Ухаалаг шавийн багшийг шүтэх хандлагыг дараах байдлаар томьёолсон нь сонирхолтой бөгөөд ач холбогдолтой. Тухайлбал, шавьд болбоос,

1. Дуулгавартай хүү мэт хандлага - өөрийн зоргоор явахаа болих, сайн сургаалыг дагах;
2. Эвдэршгүй алмаз мэт хандлага - эргэлт буцалтгүй номын мөрөөр явах. Урваж шарвалзахгүй байх;
3. Хөдөлшгүй газар мэт хандлага - шантрахгүй, хариуцлагатай байх;
4. Үүрэгтээ хариуцлагатай хандлага - зовлон тохиолдовч уул мэт, гутранги зангүй, бардамнасан аашгүй, үүрэг даалгаварт халширдаггүй, зэмлэл хүлээж чаддаг зэрэг шинжийг тус тус эзэмшинэ.

Өнөө үеийн багш шавийн харилцаанд чухал ач холбогдолтой агуулга бүхий сургаал болох нь энэ мэт олон жишээнээс харж, анхаарч ажиллах боломжтой хэмээн үзэж байна.

Мөн түүнчлэн багш, шавь хоёр биедээ хүндэтгэлтэй хандана. Өөлж муулсан тохиолдолд ном сонсох, ном номлох ёс алдагдана. “Өргөн хүндлэлийн тавин магтаал”-д “Багшаа муушаах нь туйлын их мунхаг аж. Энд гамшигт дайрагдаж, хижиг өвчинд нэрвэгдэн, алив хорд хордогдон үхэх болой. Галын дөл ба хорт могой, усан гамшиг ба хулгай дээрэм, буруу номтонд алагдан, амьтны тамд унаюу. Хэзээ ч багшийн сэтгэлийг хутган гомдоож, үл үйлдэх, хэн хэрвээ мунхгаар үйлдвээс тамд унаж, шатагдах буюу чанагдьюу” (Мягмарсүрэн, 2021) хэмээн өгүүлсэн нь шавь хүн багшийг хүндэлж байж эрдэм мэдлэгээс хүртдэг болохыг заажээ.

4. Дүгнэлт

Өнөө цагт багшийн ёс суртахууны тухай авч үзэх чухал шаардлага бидний өмнө тулгарч байна. Хэдийгээр бид хууль, дүрэм, журмыг батлан хэрэгжүүлж байгаа ч дэвшилтэт уламжлалт утга санаа бүхий судар, шастирын агуулгыг нэхэн сурвалжлах хэрэгцээ шаардлага буй хэмээн үзэж байна.


Багш мэргэжлийн хувьд ёс суртахууны үнэт зүйлс нь дийлэнхдээ соёл хоорондын ялгаанаас үл хамааран түгээмэл үйлчилдэг хэм хэмжээ, зарчмыг баримталдаг. Тухайлбал, багш үг, үйлдлээрээ бусдыг гомдоохгүй байхыг хичээх, бүх зүйлийг илүү сайн болгохын төлөө хичээх, бусдыг хүндлэх, суралцагчийн хувийн нууцыг өөртөө хадгалах, суралцагчийн алдаа дутагдлыг хэлж чиглүүлэх, засах арга хэмжээ авах, шударга байх, сэтгэл хөдлөлөө тэнцвэртэй байлгаж, биеэ барих, бусдыг өрөвдөж, санаа тавьдаг гэдгээ харуулах зэрэг олон зүйлийг шаарддаг. Богд Зонхавын “Бодь мөрийн зэрэг” зохиолд багшийн номлох үйл, суралцагчийн сонсох үйл зэргээр ялган, баримталбал зохих нийтлэг шаардлага, шалгуур, хэм хэмжээг тодорхой тусгажээ. Энэ нь дан ганц буддизмын хүрээгээр хязгаарлагдахгүй илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх ёстойг харуулж байгаа юм.

Сайн номлол олон ч “Бодь мөрийн зэрэг”-ийг үз хэмээн сургадаг ажээ. Учир нь тус зохиолд ном заах болон сонсох ёсыг нарийн тусгаж өгчээ. Ном заах болон сонсох ёс зөв бол хол, ойрын зорилго биелж, заавал ач тусаа өгдөг болохыг тэмдэглэжээ. “Бодь мөрийн зэрэг” зохиолд ном заах ёсыг ихээхэн хүч тавин анхаарах ёстойг бичсэн нь өнөө үед анхаарууштай билээ. Өөрөөр хэлбэл, багш бэлтгэх үйл ажиллагаанд цаашид бид ихээхэн анхаарч ажиллах, ингэснээрээ нийгэмд шуугиан дэгдээгээд буй багш мэргэжлийн ёс зүйд холбогдолтой олон асуудлыг шийдэх чухал гарц болно.

Ном зүй

- Багшийн ёс зүйн өнөөгийн байдал.** (2022). *Судалгааны тайлан*. Улаанбаатар [Bagshyn yos zuin unuugyn baidal. 2022. Sudalgaany tailan. Ulaanbaatar (The current state of teacher ethics. Research report)]
- Баярчимэг, Ч., Золзаяа, М., Оюунгэрэл, Д.** (2023). *Багш мэргэжлийн ёс зүй: Асуудал, хандлага*. Улаанбаатар. [Ch. Bayarchimeg, M.Zolzaya, D.Oyungerel. 2023. Bagsh mergejlyn yos zui: Asuudal, handлага. Ulaanbaatar. (Teacher Professional Ethics: Issues and Approaches)]
- Богд Зонхов.** 2006. *Бодь мөрийн зэрэг*. Улаанбаатар. (Bogd Zonhov. 2006. Bodi toryn zereg. Ulaanbaatar. (Zongkhaba Lobsangdagba. Lam rim chen bo)]
- Дарьхүү, Р.** (2012). *Багшийн ёс зүй - Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй*. Улаанбаатар. [R.Darikhoo. 2012. Bagshyn yos zui - Mergejlyn ba heregleeny yos zui. Ulaanbaatar. (Teacher Ethics - Professional and Applied Ethics)]

- Зонхова Лувсандагва.** (2004), (2007). *Их бодь мөрийн зэрэг. I-III боть.* Орч., Т.Булган. Улаанбаатар. [Zonhova Luvsandagba. 2004. 2007. *Ikh bodi moryn zereg. I-III boti.* Ulaanbaatar. (Zongkhaba Lobsangdagba. *Lam rim chen bo*]
- Мягмарсүрэн, Г.** (2021). *Бодь мөрийн зэргийн дээж бичиг.* Улаанбаатар. [G. Myagmarsuren. 2021. *Bodi moryn zergyn deej bichig.* Ulaanbaatar (Lam rim chen bo's compiled documents)]
- Наранцэцэг, Д.** (2020). *Богд Зонхавын намтар.* Улаанбаатар. [D. Narantsetseg. 2020. *Bogd Zonhavyn namtar.* Ulaanbaatar. (*Biography of Bogd Zongkhaba*)]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.